

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/016/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Говьсүмбэр аймаг  
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543179  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Цахим хаяг: [nananbayarg@audit.gov.mn](mailto:nananbayarg@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Анхтуяа  
Цахим хаяг: [ankhtuyab@audit.gov.mn](mailto:ankhtuyab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2026.02.23 № 11  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4226050088

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 135 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.37 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>196,012,009.24</u></b>	<b><u>273,877,527.24</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	15,977,369.81	10,077,369.81
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	15,977,369.81	10,077,369.81
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	15,977,369.81	10,077,369.81
31218	Ахмадын сангийн харилцах	15,977,369.81	10,077,369.81
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	31,914,189.43	31,914,189.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	54,542.43	54,542.43
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	31,859,647.00	31,859,647.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	31,859,647.00	31,859,647.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	84,870,450.00	168,635,968.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	66,870,450.00	150,635,968.00
35410	Бичиг хэргийн материал	825,900.00	648,000.00
35420	Аж ахуйн материал	108,000.00	108,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	16,220,000.00	16,860,000.00
35470	Бусад хангамжийн материал	49,716,550.00	133,019,968.00
35600	Мал амьтад	18,000,000.00	18,000,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	63,250,000.00	63,250,000.00
36600	Бусад нөөц	63,250,000.00	63,250,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,139,625,878.81</u></b>	<b><u>1,107,134,883.72</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,139,625,878.81	1,107,134,883.72
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,002,067,045.33	969,973,550.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,565,096.13	1,079,591,941.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(677,325,154.23)	(771,421,830.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	286,618,550.00	292,618,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(133,403,025.42)	(188,028,542.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,252,200.00	134,116,661.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(61,310,663.78)	(87,913,425.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,884,618.50	64,884,618.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,846,204.98)	(30,046,653.13)
39209	Зам, гүүрийн байгууламж	499,815,745.00	776,775,202.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(334,316,111.00)	(403,465,251.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	782,823,317.74	782,823,317.74
39215	Хуримтлагдсан элэгдэл	(573,691,322.63)	(679,961,039.30)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	137,558,833.48	137,161,333.48
39301	Програм хангамж	1,710,000.00	1,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,029,166.52)	(1,426,666.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	136,878,000.00	136,878,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,335,637,888.05</u></b>	<b><u>1,381,012,410.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>1,485,390.00</u></b>

41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	1,485,390.00
413	<b>Өглөг</b>	0.00	1,485,390.00
4136	<b>Бусад өглөг</b>	0.00	1,485,390.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,485,390.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,335,637,888.05</b>	<b>1,379,527,020.96</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,335,637,888.05	1,379,527,020.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	639,608,941.55	639,608,941.55
51101	Өмч: - төрийн	639,608,941.55	639,608,941.55
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(71,429,855.78)	(27,540,722.87)
51210	Өмнөх үеийн үр дүн	(80,474,206.81)	(71,429,855.78)
51220	Тайлант үеийн үр дүн	9,044,351.03	43,889,132.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	767,458,802.28	767,458,802.28
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,335,637,888.05</b>	<b>1,381,012,410.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,622,875,444.24</b>	<b>1,805,752,681.93</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>438,351,691.24</b>	<b>396,961,181.93</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	438,351,691.24	396,961,181.93
120009	Бусад орлого	1,843,100.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	292,468,581.00	316,050,763.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	144,040,010.24	80,910,418.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,184,523,753.00</b>	<b>1,408,791,500.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,865,653.00	1,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,110,653.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	880,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	875,000.00	70,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,168,658,100.00	1,407,721,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,168,658,100.00	1,407,721,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,612,874,426.49</b>	<b>1,761,863,549.02</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,612,874,426.49</b>	<b>1,761,863,549.02</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,533,697,766.69	1,623,244,782.95
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	589,286,729.34	802,859,453.61
210101	Үндсэн цалин	311,957,781.93	436,817,612.83

210102	Нэмэгдэл	160,316,745.35	289,393,140.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,990,000.00	38,550,000.00
210104	Урамшуулал	35,330,700.00	38,098,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,691,502.06	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,777,296.39	96,233,421.69
210201	Тэтгэврийн даатгал	48,769,329.40	65,907,019.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,613,512.71	7,673,005.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,842,547.36	3,736,618.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,379,503.79	3,585,173.45
210205	Эрүүл мэндийн даатгал	10,172,403.13	15,331,604.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	118,070,918.11	131,460,791.36
210301	Гэрэл, цахилгаан	20,540,104.11	33,672,127.36
210302	Түлш, халаалт	81,760,684.00	81,234,394.00
210303	Цэвэр, бохир ус	15,770,130.00	16,554,270.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	106,457,713.48	76,560,195.00
210401	Бичиг хэрэг	8,325,270.00	9,229,700.00
210402	Тээвэр, шатахуун	51,944,440.00	39,810,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,988,173.48	5,058,075.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	640,000.00	135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,345,330.00	22,326,870.00
210408	Бараа материал акталсны зардал	2,899,500.00	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	3,315,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	222,000.00	-
210604	Урсгал засвар	222,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,554,700.00	11,900,000.00
210702	Дотоод албан томилолт	11,554,700.00	11,900,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	62,694,892.78	69,927,412.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,495,467.78	67,908,250.27
210803	Даатгалын үйлчилгээ	433,425.00	549,255.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	487,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,000.00	143,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	345,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	494,407.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	575,633,516.59	434,303,509.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	162,034,897.34	80,961,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,240,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	412,358,619.25	353,341,759.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	79,176,659.80	138,618,766.07
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,310,653.00	7,150,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,110,653.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,200,000.00	7,150,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,866,006.80	131,468,766.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,866,006.80	131,468,766.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>10,001,017.75</b>	<b>43,889,132.91</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	956,666.72	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	956,666.72	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(956,666.72)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>9,044,351.03</b>	<b>43,889,132.91</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,184,523,753.00</b>	<b>1,408,791,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,865,653.00	1,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,110,653.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	880,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	875,000.00	70,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,168,658,100.00	1,407,721,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,168,658,100.00	1,407,721,500.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>15,434,656.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15,434,656.00	0.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	15,434,656.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,434,656.00	0.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,199,958,409.00</b>	<b>1,408,791,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,150,824,353.00</b>	<b>1,409,891,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,070,447,693.20</b>	<b>1,271,272,733.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	602,878,285.34	802,859,453.61
210101	Үндсэн цалин	327,959,442.65	442,879,208.89
210102	Нэмэгдэл	159,698,450.85	285,699,876.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,607,911.00	37,235,134.56
210104	Урамшуулал	34,739,537.50	37,045,234.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,872,943.34	0.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,777,296.39	96,233,421.69
210201	Тэтгэврийн даатгал	48,743,079.40	65,907,019.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,613,512.71	7,673,005.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,806,756.36	3,736,618.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,415,294.79	3,585,173.45
210205	Эрүүл мэндийн даатгал	10,198,653.13	15,331,604.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	118,070,918.11	131,460,791.36
210301	Гэрэл, цахилгаан	20,540,104.11	33,672,127.36
210302	Түлш, халаалт	81,760,684.00	81,234,394.00
210303	Цэвэр, бохир ус	15,770,130.00	16,554,270.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,241,873.48	34,881,075.00
210401	Бичиг хэрэг	7,405,670.00	6,396,700.00
210402	Тээвэр, шатахуун	19,500,000.00	20,034,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,157,173.48	5,058,075.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	640,000.00	187,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,539,030.00	3,205,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38,698,900.00	18,262,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,548,000.00	2,173,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	1,089,000.00
210604	Урсгал засвар	37,150,900.00	15,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,554,700.00	11,900,000.00
210702	Дотоод албан томилолт	11,554,700.00	11,900,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	93,015,592.78	85,838,612.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,716,167.78	83,386,450.27
210803	Даатгалын үйлчилгээ	433,425.00	549,255.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	487,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,000.00	143,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	778,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	494,407.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	101,210,127.10	89,837,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,970,127.10	89,837,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,240,000.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,376,659.80</b>	<b>138,618,766.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,510,653.00	7,150,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,110,653.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,400,000.00	7,150,000.00

<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	65,866,006.80	131,468,766.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,866,006.80	131,468,766.07
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b><u>1,150,824,353.00</u></b>	<b><u>1,409,891,500.00</u></b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>49,134,056.00</u></b>	<b><u>(1,100,000.00)</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>37,399,400.00</b>	<b>4,800,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	37,399,400.00	4,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,399,400.00	4,800,000.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>37,399,400.00</b>	<b>4,800,000.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(37,399,400.00)</u></b>	<b><u>-4,800,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	11,734,656.00	(5,900,000.00)
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	4,242,713.81	15,977,369.81
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	15,977,369.81	10,077,369.81

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	639,608,941.55	767,458,802.28	(77,985,956.75)	-	1,329,081,787.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,488,250.06)	-	(2,488,250.06)
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(80,474,206.81)</b>	-	1,326,593,537.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,044,351.03	-	9,044,351.03
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(71,429,855.78)</b>	-	1,335,637,888.05
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(71,429,855.78)</b>	-	1,335,637,888.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(71,429,855.78)</b>	-	1,335,637,888.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	43,889,132.91	-	43,889,132.91
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(27,540,722.87)</b>	-	1,379,527,020.96

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,491,903,500.00</b>	<b>1,276,322,733.93</b>	<b>215,580,766.07</b>	<b>85.5</b>
Төсвөөс санхүүжих	1,491,903,500.00	1,276,322,733.93	215,580,766.07	85.5
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,491,903,500.00</b>	<b>1,276,322,733.93</b>	<b>215,580,766.07</b>	<b>85.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,491,903,500.00</b>	<b>1,282,222,733.93</b>	<b>209,680,766.07</b>	<b>85.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,475,403,500.00</b>	<b>1,275,072,733.93</b>	<b>200,330,766.07</b>	<b>86.4</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>870,118,400.00</b>	<b>802,859,453.61</b>	<b>67,258,946.39</b>	<b>92.3</b>
Үндсэн цалин	377,879,100.00	442,879,208.89	-65,000,108.89	117.2
Нэмэгдэл	379,221,300.00	285,699,876.16	93,521,423.84	75.3
Унаа хоолны хөнгөлөлт	54,551,800.00	37,235,134.56	17,316,665.44	68.3
Урамшуулал	58,466,200.00	37,045,234.00	21,420,966.00	63.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>108,852,400.00</b>	<b>96,233,421.69</b>	<b>12,618,978.31</b>	<b>88.4</b>
Тэтгэврийн даатгал	75,432,300.00	65,907,019.90	9,525,280.10	87.4
Тэтгэмжийн даатгал	8,354,500.00	7,673,005.35	681,494.65	91.8
ҮОМШӨ-ний даатгал	6,684,400.00	3,736,618.51	2,947,781.49	55.9
Ажилгүйдлийн даатгал	1,671,400.00	3,585,173.45	-1,913,773.45	214.5
Эрүүл мэндийн даатгал	16,709,800.00	15,331,604.48	1,378,195.52	91.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>137,280,000.00</b>	<b>131,460,791.36</b>	<b>5,819,208.64</b>	<b>95.8</b>
Гэрэл, цахилгаан	30,000,000.00	33,672,127.36	-3,672,127.36	112.2
Түлш, халаалт	87,280,000.00	81,234,394.00	6,045,606.00	93.1
Цэвэр, бохир ус	20,000,000.00	16,554,270.00	3,445,730.00	82.8
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,100,000.00</b>	<b>34,881,075.00</b>	<b>7,218,925.00</b>	<b>82.9</b>
Бичиг хэрэг	7,000,000.00	6,396,700.00	603,300.00	91.4
Тээвэр, шатахуун	21,500,000.00	20,034,000.00	1,466,000.00	93.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	5,058,075.00	941,925.00	84.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	187,000.00	413,000.00	31.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,000,000.00	3,205,300.00	3,794,700.00	45.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,500,000.00</b>	<b>23,062,000.00</b>	<b>16,438,000.00</b>	<b>58.4</b>
Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	6,973,000.00	11,027,000.00	38.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,089,000.00	411,000.00	72.6
Урсгал засвар	20,000,000.00	15,000,000.00	5,000,000.00	75.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,500,000.00</b>	<b>11,900,000.00</b>	<b>5,600,000.00</b>	<b>68.0</b>
Дотоод албан томилолт	17,500,000.00	11,900,000.00	5,600,000.00	68.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>132,552,700.00</b>	<b>85,838,612.27</b>	<b>46,714,087.73</b>	<b>64.8</b>
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	128,300,000.00	83,386,450.27	44,913,549.73	65.0

Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	549,255.00	950,745.00	36.6
Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	500,000.00	487,000.00	13,000.00	97.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	143,500.00	356,500.00	28.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	778,000.00	422,000.00	64.8
Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	552,700.00	494,407.00	58,293.00	89.5
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,500,000.00</b>	<b>88,837,380.00</b>	<b>38,662,620.00</b>	<b>69.7</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	124,500,000.00	88,837,380.00	35,662,620.00	71.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	0.00	3,000,000.00	0.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,500,000.00</b>	<b>7,150,000.00</b>	<b>9,350,000.00</b>	<b>43.3</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,500,000.00</b>	<b>7,150,000.00</b>	<b>9,350,000.00</b>	<b>43.3</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,500,000.00	7,150,000.00	9,350,000.00	43.3
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,491,903,500.00</b>	<b>1,282,222,733.93</b>	<b>209,680,766.07</b>	<b>85.9</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>15,977,369.81</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>10,077,369.81</b>		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
Төсвийн байгууллага	1	1		
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>26</b>	<b>24</b>		
Удирдах ажилтан	5	5		
Гүйцэтгэх ажилтан	10	8		
Үйлчлэх ажилтан	9	9		
Гэрээт ажилтан	2	2		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,865,653.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,865,653.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,755,000.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	710,000.00	-
210401	Бичиг хэрэг	710,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	880,000.00	-
210702	Дотоод албан томилолт	880,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	165,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	165,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,110,653.00</b>	-
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>9,110,653.00</b>	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,110,653.00</b>	-
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,110,653.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>15,865,653.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,865,653.00</b>	<b>1,000,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,110,653.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	880,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	875,000.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын илрүүлэлт:**

#### **Завсрын аудитаар:**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, бараа материал, үндсэн хөрөнгө, 210901, 213209 дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 4,309.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан.

#### **3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

#### **3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 44,970.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өглөө.

##### **3.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, гүйцэтгэл цэсэд цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 17,427.6 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, бусад цэсэд хөрөнгө зарцуулахтай холбоотой 27,543.6 мянган төгрөгийн 6 шийдвэр хугацаа хоцроож мэдээсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.5, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10, 3.2.11 дахь заалтуудтай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг тухай бүрд нь түргэн шуурхай ил тод мэдээлэх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

##### **3.2.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

4. Аудитаар нийт 4,745.6 алдаа<sup>1</sup> илэрснээс завсрын аудитаар 4,309.0 мянган төгрөгийн алдааг залруулсан ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 436.6 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан байна.

**Залруулсан алдаа:**

1. Ерөнхий журналд 436.6 мянган төгрөгийн цалингийн зардлыг бууруулах бичилт хийж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын Гуравдугаар бүлэг: Зардал, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.

**Залруулаагүй алдаа:**

Байхгүй

Аудитаар нийт 2,563.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,180.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1,382.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,563.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,565.4 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### **4.1 Төлбөрийн акт**

**4.1.1** Тээвэр шатахууны зардлаас норм, норматив хэтрүүлэн 815.9 мянган төгрөгийн зарцуулалтыг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан /Жолоочийн тооцооны хуудсанд сумаас аймаг, аймгаас сум ирж, очих км-ийг 3009 км-ээр хэтрүүлж бодсон/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох, 2026.05.25-ны дотор төлбөрийн актыг барагдуулж хариу ирүүлэх

**4.1.2** Байгууллагын дотоод журмын дагуу 5 албан хаагчид нийт 2,850.0 мянган төгрөгийн тэтгэмж, тусламж олгоходоо 285.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого”, 22 дугаар зүйлийн 22.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”, дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох, 2026.05.25-ны дотор төлбөрийн актыг барагдуулж хариу ирүүлэх

**4.1.3** Албан томилолтоор ажиллах үед хоолны зардал олгосон боловч цалингаас хоолны зардал давхардуулан 80.0 мянган төгрөг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.3-т “хоолны зардал”, 2.5-д “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална” дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох, 2026.04.25-ны дотор төлбөрийн актыг барагдуулж хариу ирүүлэх

## **4.2 Албан шаардлага**

**4.2.1** Өмнөх оны аудитаар өгсөн “Он удаан жил болсон нийт 31,859.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй, хуульд заасан үүргээ биелүүлээгүй” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар

тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын Зургаадугаар бүлэг: Авлага гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учирсан хохирол барагдуулахтай холбоотой, он удаан жил болсон нийт 31,859.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах яаралтай арга хэмжээ авч шийдвэрлэх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Зардалтай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ арга хэмжээний төсөвт хогны машины шатахууны зардалд нийт 14,220.4 мянган төгрөгийг төлөвлөсөн боловч 1,329.3 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ арга хэмжээний төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар үндэслэлтэй төлөвлөж зарцуулах, батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулахгүй байх

##### **2. Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Авто, тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй 12 автомашиныг тулган баталгаажуулахад: 1. Авто тээврийн үндэсний төвд бүртгэлгүй 2 /Автобус, Соната 7/, 2. Байгууллага, иргэнд ашиглуулж байгаа 2 /Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ /Кама/, малчинд /Трактор/, ашиглах боломжгүй /фермер/ 1 нийт 5 автомашин байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглаагүй байна. /Зам ашигласан, агаарын бохирдол, автомашины татварт 53.0 мянган төгрөг төлсөн /

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын Аравдугаар бүлэг: Үндсэн хөрөнгө заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 3 "Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал" 3.6-3.8 хамааралтай байх, УСНББОУС 17-Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Авто тээврийн үндэсний төвд 2 тээврийн хэрэгслийг бүртгүүлэх, байгууллага иргэнд ямар нэгэн шийдвэргүй ашиглуулж байгаа тээврийн хэрэгслийн нөхцөл байдлыг судалж шийдвэр гаргах, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргах, тухайн байгууллагын дансанд бүртгэлгүй боловч авто тээврийн үндэсний төвд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хасуулах, авто тээврийн хэрэгслийг ашиглалтыг сайжруулах

**Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг даргын тамгын газар	2	4.7	1	4.3	1	0.4	2	4.7				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4.7</b>	<b>1</b>	<b>4.3</b>	<b>1</b>	<b>0.4</b>	<b>2</b>	<b>4.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг даргын тамгын газар	6	2.6	3	1.2	1	0.0	2	1.4				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>2.6</b>	<b>3</b>	<b>1.2</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>1.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг даргын тамгын газар	1	45.0			1	45.0		
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг даргын тамгын газар								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>45.0</b>			<b>1</b>	<b>45.0</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			